



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.9, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4, 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал А.Анандыг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Батболдыг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн гишүүнээр томилсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН